

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Газрын харилцаа, Барилга, хот байгуулалтын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

2025 онд Монгол улсын засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх 11 чиглэлийн нэг болох газрын шинэтгэлийн бодлогыг хэрэгжүүлэх, газрын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх замаар иргэдийн амьжиргааны түвшинг сайжруулахад дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэнэ. Чиглэл: Дорноговь аймгийн хөгжлийн чиг хандлагыг зах зээлийн эдийн засгийн харилцааны нөхцөлд нийцүүлэн зөв тодорхойлоход аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг даргад мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, аймгийн газрын харилцаа болон барилгын, хот байгуулалтын асуудлыг хууль тогтоомжийн дагуу, шинжлэх ухааны үндэслэлтэй зохицуулахад аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын ажил үндсэндээ чиглэгдэж байгаа юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн тухай өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль,
- Ахмад настны тухай хууль
- Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль
- Бусад

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрдлөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 723.4 сая төгрөгөөр буюу 18.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,760.0	-	1,760.0
Авлага	112,526.5	40,333.5	72,193.0
Бараа материал	91,341.9	105,862.8	(14,520.9)
Үндсэн хөрөнгө	680,782.6	577,233.1	103,549.5
Нийт хөрөнгө	886,411.0	723,429.4	162,981.6
Өр төлбөр	-	18,500.0	(18,500.0)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	886,411.0	723,429.4	162,981.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	886,411.0	723,429.4	162,981.6

Дээрх хүснэгтээс харахад авлагын дансны үлдэгдэл 40.3 сая төгрөг нь барилгын техник хяналтын зардал 20.5 сая төгрөг, ахмадын сангийн үлдэгдэл төвлөрүүлсэн 1.3 сая төгрөг, мөн тус байгууллагын авто тээврийн хэрэгслийн дансанд бүртгэлтэй фургон машиныг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолын дагуу дуудлага худалдааг зохион байгуулж худалдсан дуудлага худалдааны орлого 18.5 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас татан төвлөрүүлсэн тус тус авлагууд байна.

Бараа материал дансны үлдэгдэл 105.9 сая төгрөг болж өмнөх оноос 14.5 сая төгрөгөөр өссөн байна.

Өр төлбөрийн дансанд бүртгэлтэй 18.5 сая төгрөг нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 268 дугаар тогтоолын дагуу авто тээврийн хэрэгслийн дуудлага худалдааны орлогыг тус байгууллагын дансанд татан төвлөрүүлэх дүн бөгөөд сангийн яамнаас цалингийн зардлаас бусад гүйлгээг хязгаарласантай холбоотойгоор үүссэн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 103.5 сая төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардал өссөнтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өмнөх оноос 162.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалж байна.

Ерөнхий чиглэлийн нэгдсэн судалгааны хувьд тус байгууллагад 4.0 сая төгрөгийн өртөгтэй 3 нэр төрлийн программ хангамж /Acologic санхүүгийн программ, төсвийн программ, fiscus санхүүгийн онлайн программ/ бүртгэлтэй байна. Лиценз сунгалттай холбоотой зардал гараагүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд нийт зардлыг 1.146.2 сая төгрөгөөр баталж өмнөх оноос 181.3 сая төгрөгөөр буурсан нь 2025 онд улсын төсвийн орлого бүрдэхгүй, төсөв хүндэрсэнтэй холбоотой цалин хөлснөөс бусад урсгал үйл ажиллагааны зардлыг бууруулж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр төсвийн тодотголоор нийт 1,146.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,041.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 105.0 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос олгохоор баталсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,095.4 сая төгрөг буюу 95.6 хувь, 50.8 сая төгрөгийн хэмнэлттэй байна.

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт, хувиар
71504 – Газрын зураглал кадастр					
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,038,477.3	997,733.8	40,743.5	96.1
2	Байр ашиглалтын үйлчилгээ	13,036.9	10,175.8	2,861.1	78.0
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	7,226.8	0	7,226.8	0.0
4	Барилгын техник хяналт	87,500.0	87,500.0	0.0	100.0
Нийт мөнгөн дүн		1,146,241.0	1,095,409.6	50,831.4	95.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Ерөнхий чиглэлийн дагуу авсан судалгааны талаар

Судалгаа-1 Унаа, хоолны хөнгөлөлт (210103)-ийн зардлын тарифын судалгаа:

Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын 2023 оны А/35 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын дотоод журам”-ын 10.1.6 дахь заалтын дагуу нэг хүнд ногдох 1 өдрийн хоолны хөнгөлөлтийг 15.0 мянган төгрөгөөр тогтоосон байна. Тайлант онд 81.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 75.9 сая төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулсан байна.

Судалгаа-2 Гадаад томилолт, арга хэмжээний зардал:

Тус байгууллагад гадаад томилолт, арга хэмжээний зардал байхгүй байна.

Судалгаа-3 Төрд учирсан хохирол барагдуулах зардал:

Төрд учирсан хохирлыг барагдуулах зардал гараагүй байна.

Судалгаа-5 Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний зардал:

Тайлант онд дотоод сургалтыг нийт албан хаагчдын дунд 1 удаа, хурал зөвлөгөөнийг 1 удаа зохион байгуулж, албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтад нийт 7 албан хаагчийг хамруулж тайлант хугацаанд нийт 5.9 сая төгрөгийн зардлыг зарцуулсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад 1.3 сая төгрөгийн илүү зарцуулалттай байна.

Судалгаа-7 Байгууллагуудын орон тооны цомхотголын судалгаа:

Тайлант онд 38 орон тоотой, 892.5 сая төгрөгийн цалингийн зардал батлагдсанаас, 25 орон тоотойгоор, 856.2 сая төгрөгийн цалингийн зардлын гүйцэтгэлтэй ажилласан байна.

Судалгаа-8 Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн мэдээлэл:

Тайлант онд “Ди медиа ХХК”-тай хамтран ажиллах гэрээ байгуулсан бөгөөд хэвлэл мэдээлэл, зар сурталчилгааны зардалд 3.6 сая төгрөгийн зардлыг зарцуулсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар Аймгийн засаг даргын Тамгын газраас барилгын техник хяналтын зардал 296.2 сая төгрөг, орон нутгийн нэмэгдлийн санхүүжилт 67.6 сая төгрөг, барилгын лабораторийн шинжилгээний орлого 11.1 сая төгрөг, газрын үйл ажиллагааны орлого 126.1 сая төгрөг, дуудлага худалдааны орлого 18.5 сая төгрөгийн орлого нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлснийг тус бүр үйл ажиллагааны зардалд зарцуулж үлдэгдэл 188.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Ахмадын сангийн төсөв

Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын дагуу Ахмадын санг байгуулан ажиллаж хэвшсэн бөгөөд тайланд онд цалингийн төсвөөс 6 сая төгрөгийг ахмадын сангийн төрийн сангийн дансанд шилжүүлэн, өөрийн байгууллагын ахмад настанд хүндэтгэл, дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд нийт 6.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Ахмадын сангийн дансны тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.7-д харуулав.

3.5.5. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бараа, ажил, үйлчилгээ мөн байхгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2025 оны оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Мөнх-Оргил гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Э.Энхцэцэг, аудитын менежер У.Оюунтүлхүүр, газрын дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 37 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны жилийн эцсийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт орлого буюу 3,118.4 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 31.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар тооцож 24.9 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага дээд шатны байгууллагаас өгсөн заавар, зөвлөгөөг мөрдөж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны мэдээллийн системд байршуулбал зохих мэдээллээс 2,262.1 сая төгрөгийн 92 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант оны 1-6 сарын санхүүгийн тайлан, баримтад завсрын аудитыг хийн санхүүгийн тайланг үнэн зөв тайлагнаагүй байх, цалингийн зардлыг үнэн зөв тооцож тайлагнаагүй байх, зардлыг зориулалт бусаар зарцуулсан байх, Үндсэн хөрөнгө, бараа материалын тайланг зөрүүтэй тайлагнасан байх, Үндсэн хөрөнгийн элэгдлийг үнэн зөв тооцоолоогүй байх, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, бүрэн хөтлөөгүй байх, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байх зэрэг 7 горим сорилыг хэрэгжүүлж төлөвлөгөө хөтөлбөрийг батлуулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 4,039.7 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 2 зөвлөмж өгсөн ба хэрэгжилтийг бүрэн хангасан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	0				
Албан шаардлага	0				
Зөвлөмж	2	4039.7	2	4039.7	100
Нийт дүн	0				

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татсан асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 43.5 сая төгрөгийн 5 алдаа, 1 зөвлөмж, 1 албан шаардлага илэрснээс алдааг аудитын явцад бүрэн залруулсан.

5.1 Аудитын залруулга

1. Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналд 4 төрлийн хөрөнгийн үлдэх өртгийг 340.3 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна.

2. Байгууллагын 3 албан хаагчийн байгууллагаас төлөх НДШ 12.5%-ийг 13.5 хувиар тооцож 436.2 мянган төгрөгийг илүү шилжүүлж тайлагнасан байна.

3. Үндсэн хөрөнгө, бараа материалыг ангиллын дагуу бүртгээгүй, тухайлбал аж ахуйн материалын дансанд 1 нэр төрлийн 8,071.0 мянган төгрөгийн дохиоллын системийг бүртгэж тайлагнасан. Мөн аж ахуй, бичиг хэргийн материалын дансны үлдэгдэлд 107 нэр төрлийн 11,748.7 мянган төгрөгийн зарцуулсан материалыг үлдэгдлээр тайлагнасан байна.

4. Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг үзэхэд 28 нэр төрлийн хөрөнгийн 19,018.8 мянган төгрөгийн элэгдэл тооцоогүй орхигдуулсан байна.

5. Санхүүгийн тайланд тайлант үеийн үр дүнг 3.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

5.2 Өгсөн зөвлөмж

Илрүүлэлт 1. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга нь Төрийн албаны шалгалт өгөөгүй 3 иргэнтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулж Төрийн захиргааны албан тушаалын орон тоонд ажиллуулсан байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2-т "Төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас болон холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас сонгон шалгаруулж томилох" 27.1.3-т "Төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоог энэ хуулийн 27.1.2-т заасны дагуу нөхөх боломжгүй бол төрийн албан хаагчийн нөөцөд байгаа иргэдээс сонгон шалгаруулж томилох" гэж заасныг тус тус зөрчсөн байна

Өгсөн зөвлөмж: Төрийн жинхэнэ албан тушаалд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу шаардлага хангасан албан хаагч ажиллуулсан байх.

5.3 Албан шаардлага

1. Бараа үйлчилгээний бусад зардлаас (210901) шатахуун, сургалт, ярианы төлбөр, архив бичиг хэргийн материалыг худалдан авч, 7,600.7 мянган төгрөгийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”* гэж заасантай нийцэхгүй байна.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлж биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс					
							Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
ҮХ-ийн журналд үлдэх өртгийг зөрүүтэй тайлагнасан.	1	340.3			1	340.3	1	340.3	-	-	-	-
3 албан хаагчийн цалинг НД-ын тайланд илүү тусгасан байна.	1	436.2			1	436.2	1	436.2	-	-	-	-
ҮХ, БМ-ыг ангиллын дагуу бүртгээгүй байна.	1	19,819.7			1	19,819.7	1	19,819.7				
ҮХ-ийн элэгдэл тооцоогүй байна.	1	19,018.8	1	19,018.8			1	19,018.8				
Санхүүгийн тайланг үнэн зөв тайлагнаагүй байна.	1	3,851.2			1	3,851.2	1	3,851.2				
Дүн	5	43,466.2	1	19,018.8	4	24,447.4	5	43,466.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ерөнхий шалгалт өгөөгүй гэрээт ажилтан ажиллуулсан байна.	1	-					1	-	-	-
Зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.	1	7,600.7			1	7,600.7	-	-	-	-
Дүн	2	7,600.7			1	7,600.7	-	-	-	-